



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/435

Хэрлэн сум

Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 2017 оны Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.2, 5.1.3, 5.1.4, 5.1.5 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, 6.5, 6.6, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5, 9.6, 9.7 дахь хэсэг, 9.8.1, 9.8.2 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.2, 28.4 дэх хэсэг, Малчны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.5 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зооноз, архаг халдварт малын бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад аймгийн хэмжээнд нийт охин төл малыг бүрэн хамруулах ажлыг 2025 оны 08 дугаар сарын 15-ний өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.


2.Уг ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах аймгийн Онцгой комиссын гишүүдийн хуваарийг хавсралтаар баталсугай.

3.Малчдад урьдчилан мэдэгдэж тарилгын хашаа, хоолойг бэлтгүүлэх, дархлаажуулалтад ажиллах хүн хүч, машин техник, шатах тослох материалын бэлэн байдлыг хангуулж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад шаардагдах вакцин, мэргэжил арга зүй, заавар зөвлөмжөөр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга (Н.Анхбаяр)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

ДАЮУРБУНЬ



07
А/405

Аймгийн Засаг даргын 2025 оны
дугаар сарын 25-ний өдрийн
дугаар захирамжийн хавсралт

Д/Д	Сумдын нэр	Онцгой комиссын гишүүдийн нэрс	Албан тушаал
1	Галшар	Б.Амгаланбат	Байгаль орчны газрын дарга
2	Баянхутаг	Б.Өнөрцолмон	Аймгийн Засаг даргын орлогч
3	Баянмөнх	О.Баярлхагва	Тагнуулын хэлтсийн дарга
4	Дархан	Б.Золбоо	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
5	Дэлгэрхаан	А.Жаргалсайхан	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
6	Жаргалтхаан	Ж.Эрдэнэбат	Онцгой байдлын газрын дарга
7	Цэнхэрмандал	Ү.Энх-Ариунаа	Улаан загалмайн хорооны дарга
8	Өмнөдэлгэр	Д.Батхүү	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
9	Батширээт	Л.Цэнддорж	Цэргийн штабын дарга
10	Биндэр	Л.Дашнамжилмаа	Эрүүл мэндийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
11	Баян-Адарга	Н.Анхбаяр	Мал эмнэлгийн газрын дарга
12	Дадал	Б.Түмэнжаргал	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
13	Норовлин	Б.Бат-Эрдэнэ	Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга
14	Батноров	Д.Баярхүү	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
15	Баян-Овоо	Х.Уртнасан	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга
16	Мөрөн	Н.Үнэнбат	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
17	Хэрлэн	Д.Эрдэнэбаатар	Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын Захирагч
18	Бор-Өндөр	Э.Жавхлантөгс	Цагдаагийн газрын дарга